

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэргэлэн сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2024/012/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат Бус Аудиторын Дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 418

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Сэргэлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргэлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022210

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Сэргэлэн сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 3/06 дугаар тогтоолоор 94.4 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит Хийсэн Санхүүгийн Нэгтгэсэн Тайлан, Төсвийн Гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	706,576.40	813,403.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	293,694.50	421,407.00
33	АВЛАГА	168,784.30	123,391.90
35	БАРАА МАТЕРИАЛ	168,790.60	173,063.40
36	НӨӨЦИЙН БАРАА	75,307.00	95,541.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,159,213.40	3,543,314.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,159,213.40	3,543,314.90
39200	Биет хөрөнгө	2,050,092.50	3,424,423.30
39300	Биет бус хөрөнгө	109,120.80	118,891.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,865,789.80	4,356,718.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,865,789.80	4,356,718.80
51	Засгийн газрын хувь оролцоо	2,865,789.80	4,356,718.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	614,160.10	614,160.10
51200	Хуримтлагдсан үр дүн	2,073,529.10	3,564,458.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,100.50	178,100.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,865,789.80	4,356,718.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,444,059.70	3,871,703.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	407,634.80	628,480.20
110	Орлогын албан татвар	159,381.20	329,770.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	165,308.80	367,803.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,927.50	-38,032.80
113	Хөрөнгийн албан татвар	232,267.90	287,880.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	15,985.70	10,828.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	922,162.10	1,929,939.70
120	Нийтлэг татварын бус орлого	825,736.10	1,857,152.20
122	Тусламжийн орлого	96,426.00	72,787.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,114,262.80	1,313,283.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,259,662.30	1,643,094.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,259,662.30	1,643,094.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,034,785.20	1,548,653.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,740.80	782,815.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,965.80	94,699.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,952.10	155,949.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,096.40	33,592.70
2105	Нормативт зардал	210	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,977.10	12,400.40
2107	Томилолт, зочны зардал	9,261.00	15,589.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,659.50	38,385.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	224,922.60	415,222.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,224,877.10	94,441.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,184,397.40	2,228,609.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	545,137.30	737,680.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	639,260.10	1,490,929.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

			/мянган төгрөгөөр/
Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,230,529.70	2,230,529.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,000.00	-4,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,226,529.70	2,226,529.70
9	Тайлант үеийн үр дүн	639,260.10	639,260.10
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,865,789.80	2,865,789.80
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,865,789.80	2,865,789.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,865,789.80	2,865,789.80
19	Тайлант үеийн үр дүн	1,490,929.00	1,490,929.00
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,356,718.80	4,356,718.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/мянган төгрөгөөр/	
Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,683,187.60	2,158,424.00	
11	ТАТВАРЫН ОРЛОГО	407,634.80	628,480.20	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,290.10	216,660.10	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,114,262.80	1,313,283.70	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,043,890.20	1,361,698.90	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,043,890.20	1,361,698.90	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,013.10	1,267,257.60	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,224,877.10	94,441.30	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	639,297.40	796,725.10	
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	636,631.90	669,012.70	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	636,631.90	669,012.70	
2200	Дотоод эх үүсвэрээр	636,631.90	669,012.70	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-636,631.90	-669,012.70	
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-56,000.00	0	
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	56,000.00	0	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-53,334.50	127,712.50	
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	347,029.00	293,694.50	
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	293,694.50	421,407.00	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,447,156.0	1,946,333.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,348,075.8	1,283,285.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,257,822.6	1,193,553.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	807,633.0	782,815.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,357.3	94,699.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,931.2	155,634.2
2104	Хангамж, бараа материалын зардал	26,324.0	26,300.3
	Нормативт зардал	1,401.4	1,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,699.8	19,170.3
2107	Томилолт, зочны зардал	15,165.5	15,139.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,754.2	3,096.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,556.2	95,298.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,253.2	89,731.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,253.2	89,731.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	908,961.4	663,047.8
	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	190,118.8	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,447,156.0	2,073,663.90
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,905,690.8	1,885,988.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	468,677.7	114,887.8
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	72,787.5	72,787.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		153,214.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		280,545.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,590.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,590.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,880.5
2102	Хангамж, бараа материалын зардал	3,400.7
2107	Томилолтын зардал	450.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,029.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,709.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,709.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,590.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,590.0

Гурав. Аудитын Илрүүлэлт

Аудитаар нийт 208.8 сая төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Орон нутгийн хөгжлийн сангийн 18.7 сая төгрөгийн авлага 2014 онд үүссэн бөгөөд тооцоо нийлсэн актгүй байна. Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах.

3.2 Зөвлөмж

Хоршоо хөгжүүлэх сангаас 190.1 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч гүйцэтгэлээр ямар ч зээл олгоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ; 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасны дагуу хүрэх үр дүнг ханган ажиллаагүй байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар Илэрсэн Буруу Илэрхийллийн Нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Авлага тооцоо нийлсэн актгүй	1	18.7			1	18.7							
Зээл олгохоор төлөвлөсөн ч ямар ч зээл олгоогүй.	1	190.1					1	190.1					
Дүн	2	208.8			1	18.7	1	190.1					

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.